

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН НЭРЭМЖИТ “ОНЫ ШИЛДЭГ АЖ АХУЙ НЭГЖ, МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн түншлэлийн хүрээнд хамтранажилладаг “Оны шилдэг аж ахуй нэгж, мэргэжлийн холбоо” шалгаруулахад энэхүү журмыг баримтална.
- 1.2. Энэхүү журмын зорилго нь Өвөрхангай аймаг дахь Политехник коллеж, түншлэгч аж ахуй нэгж байгууллага, мэргэжлийн холбооны хамтын ажиллагааг өргөжүүлэхэд оршино.
- 1.3. Оны шилдэг аж ахуй нэгж, мэргэжлийн холбоо шалгаруулах журам нь Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль бусад баримт бичигтэй нийцсэн байна.
- 1.4. Журмыг Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагатай хамтран ажиллаж буй түншлэгч аж ахуй нэгж байгууллагууд, мэргэжлийн холбоод дагаж мөрдөнө.

Хоёр. Оны шилдэг аж ахуй нэгж, мэргэжлийн холбоо шалгаруулах шалгуурзүүлэлт

- 2.1.Хамтын ажиллагааны гэрээтэй аж ахуй нэгж, мэргэжлийн холбоод байх
- 2.2.Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн суралцагчдыг дадлагын байраар хангаж, дадлагыг чанартай үр дүнтэй зохион байгуулан суралцагчдыг мэргэжлийн ур чадвар эзэмших, мэргэжлийн чиг баримжаатай болоход нь бүх талын дэмжлэг үзүүлсэн байх
- 2.3.Үйлдвэрлэл дээрх сургалтыг Өвөрхангай аймаг дахь Политехник коллежтой хамтран зохион байгуулж, “багш-инженер солилцоо”-ны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэн, туршлага солилцох
- 2.4.Мэргэжилтэй ажилтан бэлтгэх чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг хэлэлцэх, үйлдвэрлэл дээрх нэвтэрч буй шинэ техник тоног төхөөрөмжийг сургалтанд нэвтрүүлэхэд анхааран ажиллах
- 2.5.Мэргэжлийн багш нартай хамтран сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүн бэлтгэх
- 2.6.Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахад хамтарч ажиллах, саналдүгнэлт өгсөн байх
- 2.8.Мэргэжлийн багш, суралцагч, ажил олгогчдын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулагддаг ур чадварын уралдаан, тэмцээнийг хамтран зохион байгуулах, улс, бүсийн ур чадварын уралдаан, тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлэх
- 2.9.Мэргэжлийн холбоод, ажил олгогчдын дунд зохион байгуулагдаж байгаа уулзалт, сургалт, зөвлөгөөн, олон талт арга хэмжээнд бүтээлч санаачлагатай оролцсон байх.
- 2.10. Үнэлээчийн сургалтад хамрагдаж үйлдвэрлэлийн дадлага болон төгсөлтийн үнэлгээнд оролцож, дадлагын газарт үнэлгээ өгч ажилласан байх
- 2.11. Политехник коллежийн төгсөгчдийг ажлын байраар хангах, хөдөлмөрт бэлтгэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарч ажилласан байх.
- 2.12. Нийгмийн хариуцлагаа дээшлүүлэх ажлын хүрээнд Политехник коллежийн суралцагчдын дунд зохион байгуулж буй үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- 2.13. Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдлыг судлахад хамтран ажилласан байх

Гурав. Түншлэгч аж ахуй нэгж, мэргэжлийн холбоодыг сонгон шалгаруулах ажлын зохион байгуулалт

- 3.1. Шалгуур хангасан аж ахуй нэгж, мэргэжлийн холбооны материалыг 12 дугаар сарын 10-ны дотор хүлээн авч Мэргэжлийн боловсрол сургалтын орон нутгийн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэн шалгаруулна.
- 3.2. Шилдэг аж ахуй нэгж, мэргэжлийн холбоог Мэргэжлийн боловсрол сургалтын орон нутгийн албар зөвлөлийн даргын нэрэмжит өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж

урамшуулна.

- 3.4. Мэргэжлийн боловсрол сургалтын үндэсний зөвлөлийн Өвөрхангай аймагдахь салбар зөвлөлийн даргын нэрэмжит 2 хүртэлх “Оны шилдэг аж ахуй нэгж, мэргэжлийн холбоо”-г шалгаруулан урамшуулахад шаардагдах хөрөнгийг орон нутгийн салбар зөвлөлийн тухайн жилд зарцуулагдах төсвөөс санхүүжүүлнэ.
- 3.5. “Оны шилдэг аж ахуй нэгж, мэргэжлийн холбоог”-оор шалгарсан тухай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, алдаршуулах ажлыг зохион байгуулна.